



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, 15,202,700.00 (арван таван сая хоёр зуун хоёр мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны даргын үүрэг гүйцэтгэгч Л.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оролцуулж байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
257 дугаар тогтоолын хавсралт

**ДЭЛХИЙН ӨВ-ОРХОНЫ ХӨНДИЙН СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 498 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Соната-5, 37-01 ӨВА /арал- КМНЕН41ВР2А625653, хөдөлгүүр-0295546/	2002/2003	225000	15,202,700.00	15,202,700.00	-	1,000,000.00	500,000.00
	Нийт үнэ			15,202,700.00 (арван таван сая хоёр зуун хоёр мянга долоон зуун)	15,202,700.00 (арван таван сая хоёр зуун хоёр мянга долоон зуун)	-	1,000,000.00 (нэг сая)	500,000.00 (таван зуун мянга)